

## Эрдэмтний индэр

Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union

Erasmus+

ERASMUS+  
INTENSE**Б. Баярхүү: Докторын олон улсын нэгдмэл хөтөлбөр боловсруулах төслийг хамтран хэрэгжүүлж байна**

**- Ховд их сургууль баруун бүсийн оюуны төв хэмээн аль хэдийнээ хүлээн зөвшөөрөгдсөн. Гадаад дотоодын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлж ирсэн арвин туршлагатай. Таны удирдан хэрэгжүүлж буй төслийн тухай яриагаа эхэлье?**

-2017-2018 оны хичээл-ийн жилээс эхлэн Ховд их сургуулийн баг, Ази, Европын 7 орны 11 их дээд сургуулийн эрдэмтэдтэй хамтран "ERASMUS + Дээд боловсролын чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд "Байгаль орчны бодлого, менежмент, технологийн чиглэлээр хамтарсан докторын хөтөлбөр боловсруулах" төслийг хэрэгжүүлж байна. Энэ төсөл дээр Украины Одессийн байгаль орчны их сургууль, Харьковскийн их сургууль, Украины ШУА-ийн Карпатын экологийн хүрээлэн, Монгол улсын их сургууль, Ховд их сургууль, Вьетнам улсын Ханойн Байгалийн шинжлэх ухаан ба технологийн их сургууль, Хо Ши Миний байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны их сургууль, Европын холбооноос Естоны Хөдөө аж ахуйн их сургууль, Австрийн байгалийн нөөц ба хөдөө аж ахуйн их сургууль, Латвийн их сургууль, Нидерланд улсын Судалгаа,

Ховд их сургууль олон улсын их дээд сургуулиуд, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран судалгааны олон төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлдэг. Энэ удаагийн ярилцлагын зочноор Ховд их сургуулийн Байгаль шинжлэл, технологийн сургуулийн Геологи, газарзүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор Б.Баярхүүг "Эрдэмтний индэр" буландаа урилаа. Түүний хувьд 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн Ховд их сургууль дээр хэрэгжиж буй "Байгаль орчны бодлого, менежмент, технологийн чиглэлээр хамтарсан докторын хөтөлбөр боловсруулах" төслийн багийн ахлагчаар ажиллаж, төслөө амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү төслийг Европын холбооны Соёл боловсролын ерөнхий агентлагийн санхүүжүүлжтэй 2018-2020 онд Ази ба Европын 7 орны 11 их дээд сургуулийн баг "ERASMUS+Дээд боловсролын чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд гүйцэтгэх юм байна. Ингээд хүндэт зочинтойгоо ярилцсанаа толилуулъя.

вэ?

- Төслийг хэрэгжүүлснээр суралцагчдын судалгааны орчныг сайжруулах, докторын хамтарсан хөтөлбөрийн тодорхойлолт боловсруулах, INTENSE олон улсын сүлжээг бий болгох, докторын хөтөлбөрийн судалгаа, сургалтын орчныг судлах, хамтран ажиллах,

судлаачид маань оролцлоо. Ховд их сургуульд Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа "Хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн ахисан түвшний нэгдсэн хөтөлбөр"-ийн анхны зуны сургалт "Тогтвортой хөгжилд шилжих үеийн урьдчилан сэргийлэх зарчим:

Өнгөрснөө эргэн харж, ирээдүйг төлөвлөж, үйлдэх нь" (The Pre-cautionary Principle in Sustainability Transitions: Thinking forwards, Looking backwards, Acting)

сэдвийн дор 2018 оны 06 дугаар сарын 28-аас 07 дугаар сарын 04-ний өдрүүдэд Унгар Улсын нийслэл Будапешт хотноо амжилттай



олон нийтэд нээлттэй цахим сургалтын модульг бий болгох, түнш байгууллагуудын докторын хөтөлбөрийн оюутнуудыг харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх сургалтанд хамруулах зэрэг ажлууд хийгдэж, үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна.

- Төслийн хүрээнд сургалт, аргазүйн чиглэлийн ямар ажлууд хийгдэж байгаа вэ?

- Төслийн ажлын хэсгийн үүлзалт 2018 оны 03 сарын 26-29-ний өдрүүдэд Австри улсын Вена хот дахь Байгалийн нөөц ба

руулах асуудал гэж байна. Тэгэхээр өнөөгийн нөхцөлд улс орон бүрт тулгарч буй асуудлуудтай нягт холбоотой байж таарах байх. Сургалтуудын агуулгад энэ талаар хэрхэн тусгагдсан бол? Ер нь дэлхий нийтийн түгээмэл шинж чанартай тулгамдсан асуудлууд тухайлбал хүн амын суурьшил, төвлөрөлттэй холбоотой төлөвлөлт зохицуулалтыг шинжлэх ухаанчаар шийдэх талаар нэлээд анхаарал хандуулсан зүйлүүд бий. Тухайлбал өнгөрсөн зун INTENSE төслийн хүрээнд Беларусь улсад зохион байгуулагдсан "NEXT 2018-Nature-Based Solutions for Smart Cities" сэдэвт зуны сургалтыг дурьдаж болно. Үүнд ХИС-ийн БШТС-ийн багш доктор, дэд проф. А.Амаржаргал, доктор Д.Өнөрнасан нар оролцсон.

Түүнчлэн 2018 оны 08 дугаар сарын 14-26-ны өдрүүдэд Беларус улсын Могилев хотноо Орос-Беларусын их сургууль дээр зохион байгуулагдсан "Next 2018-Nature-Based Solutions for Smart Cities" сургалтыг хэлж болно. Уг сургалтын хүрээнд байгаль орчинд суурилсан ухаалаг хотуудыг бий болгох ямар болохыг авч үзсэн. Энэ талын онол, арга зүй, хэрэглээ тэрчилэн ухаалаг



курс-2 хичээлээр боловсруулах даалгавартай байгаа. Монгол, Вьетнам, Украин улсуудын Хүрээлэн буй орчны чиглэлийн докторын сургалтын судалгаа, сургалтанд оролцож буй байгууллагуудаас авах судалгааны асуулга бэлтгэж монгол хэлнээ орчуулан санал асуулга авах, түүнийгээ боловсруулах ажил хийж байна. Мөн төслийн үйл ажиллагааны хүрээнд Ховд их сургуулийн

багш нар гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлснээс гадна докторын сургалтанд хэрэглэгдэх "Ахьсан түвшний сургалтын танхим"-ыг байгуулж, уг танхимд 41,6 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлээд бгаа юм.

**Ярилцсан баярлалаа. Та бүхний эрдэм судлалын ажилд амжилт хүсье.**

**БҮХ НИЙТЭЭРЭЭ  
АНХААРЪЯ**

Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв, олон зууны түүхтэй Ховд хотынхоо тохижилт, соёлжилтонд дараахь зүйлийг анхаарч хэрэгжүүлэхийг ахмад настнууд, залуучууд, хүүхэд багачууддаа уриалж байна.

Юуны өмнө өмнөх жилүүдэд хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилт соёлжилтын ажлыг хайрлан хамгаалж улам бүр сайжруулж, шинэ бүтээн байгуулалтыг өрнүүлж ажиллах нь та бидний хойшлуулшгүй зорилт байвал зохилтой. Хотоо цэвэр цамцгар байлгаж хол, ойрын зочид төлөөлөгчид гийчний сэтгэлд нийцтэй байлгахад дараахь хэдэн зүйлд зайлшгүй анхаарах цаг болж байна.

Албан байгууллага аж ахуйн нэгжүүд орчин тойрч...



нөөц ба хөдөө аж ахуйн их сургууль, Латвийн их сургууль, Нидерланд улсын Судалгаа, технологи, боловсролын Erda байгууллагууд хамтран ажиллаж байгаа юм. Тодруулбал Ази, Европын холбооны олон их дээд сургууль хамтран хэрэгжүүлж байгаагаараа нэлээд онцлогтой гэж хэлж болно.

#### -Төслийн гол зорилго нь юу вэ?

- Хамтрагч орны их дээд сургуулиудын хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн чиглэлийн докторын хөтөлбөрүүдийг нэгтгэж, судалгааны хамрах хүрээ, үйл ажиллагааны нийтлэг дүрэмд суурилсан үндэсний хэмжээний докторын хамтарсан сургуулийг бий болгох, улмаар докторын сургалтын практик ач холбогдол, мэргэшлийн ур чадварыг сайжруулах, INTENSE олон улсын сүлжээгээр эдгээр докторын сургуулиудыг бэхжүүлэх нь төслийн эхний шатан дахь гол зорилго болж байна.

Мөн одоогийн сургалтын агуулгыг нэгтгэх, уян хатан судалгаа сургалтын чиглэлийн хяналт, тогтолцоо, хичээлүүдийг үнэлэх боломжийг бий болгох, судалгааны ур чадварыг үнэлж түгээх замаар докторын сургалтын орчныг бэхжүүлэх, INTENSE нь докторантуудын сургалтын хөтөлбөрийг олон сонголттой байх нөхцлийг судлах, цаашид хамтрагч орнуудын их дээд сургуулиудаас боловсруулж цуглуулсан олон нийтэд нээлттэй цахим хичээлийг мэдээллийн технологийн орчноор бий болгож боловсронгуй болгох боломжийг судлах, цахим сургалтын модулд ганцаарчилсан сургалтын багцыг бий болгох, Докторантуудын чадавхийг бэхжүүлэх, судалгааны үр дүнг олон улсад болон Европын холбооны судалгааны сүлжээгээр дамжуулан хэвлүүлэхийг нэмэгдүүлэх, хамтарсан судалгааг өргөжүүлэх, практикт чиглэсэн судалгааны сэдэвт ажил гүйцэтгэхэд туслан дэмжих зэрэг асуудлуудыг цаашдын зорилго болгон тавьж байгаа.

- Төсөл маш өргөн хүрээг хамарч хэрэгжих юм байна. Төсөл хэрэгжээд дуусахад гарах үр дүн нь юу

сарын 26-29-ний өдрүүдэд Австри улсын Вена хот дахь Байгалийн нөөц ба хөдөө аж ахуйн их сургууль дээр зохион байгуулагдсан. Уулзалт семинарт миний бие, төслийн багийн гишүүн Химийн тэнхимийн эрхлэгч дэд проф А.Амаржаргалын хамтаар оролцоод ирлээ. Энэ уулзалтаар төсөлд оролцож буй их дээд сургуулийн зохицуулагч, багийн гишүүдэд төслийн ажлын график, төсөл гүйцэтгэхэд анхаарах бичиг баримт боловсруулалтын стандартууд, төслийн багийн хамтран ажиллах стратегийн талаар зөвлөгөө өгсөн. Уулзалтанд багийн гишүүн их дээд сургуулиуд өөрсдийн байгууллагын талаар танилцуулга хийхээр төлөвлөгдсөн байсан л даа. Төслийн удирдагчийн хувьд "Western Mongolia and Khovd state university" сэдвээр өөрийн сургуулийн байгалийн ухааны чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж ирсэн байдал, судалгааны объект, ахисан түвшний байгалийн ухааны сургалтын түүх, кредит цагийн бүтэц, сургалтын онцлогийн талаар танилцуулсан.

Мөн төсөлд оролцогч байгууллагуудын үндэсний семинар 2018 оны 04 сарын 30-ны өдрөөс 05 сарын 01-ний хооронд болсон. Энэхүү семинар нь судлаач оюутнуудын судалгааны цар хүрээ, байгалийн ухааны докторантурын сургалтын түүх, агуулга, судлаачдын судалгааны чиглэл, төсөл гүйцэтгэх ажлын зааварчилгаа, холбогдох бичиг баримт боловсруулах зөвлөгөөг өгөх зорилготой байсан юм. Энэ хүрээнд миний бие "Ховд их сургууль дахь Газарзүйн ахисан түвшний сургалтын өнөөгийн байдал", доктор Н.Тэгшжаргал "Ховд их сургууль дахь биологийн ахисан түвшний сургалтын одоогийн байдал" сэдвээр танилцуулга хийж, докторант Б.Хишигжаргал, магистрант Э.Эрхэмбилэг нарын судалгааны ажлын явцтай танилцаж зөвлөгөө өглөө. Мөн Төв Европын их сургууль дээр зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжилд шилжих үеийн урьдчилан сэргийлэх зарчим" сэдэвт сургалтанд багш

явагдсан. Энэхүү сургалтын агуулга нь тогтвортой хөгжилд шилжих үед урьдчилан сэргийлэх зарчмыг үр дүнтэй, зохистой хэрэглэхэд тулгарч болох сорилт бэрхшээлүүд болон уг зарчмыг хэрэгжүүлэх боломжтой арга замуудын талаар судлахад чиглэгдсэн. Сургалт нь урьдчилан сэргийлэх зарчим, эрсдлийн үнэлгээ, менежмент, хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн судалгаа, шинжлэх ухаан, технологийн судалгаа, инновацийн засаглал, байгаль орчны засаглал, бизнесийн өөрчлөлт, урт хугацааны шилжилтийн талаар мэргэшсэн чадварлаг эрдэмтэн, мэргэжилтнүүдэд тулгуурлаж явагдсан ба тэдгээр эрдэмтдийн тусламжтайгаар сургалтын агуулгыг төрөлжүүлэн боловсруулж, нийтийн хүртээл болгосон.

Мөн судалгаа болон туршлагын хоорондын уялдааны цэг дээр стратегийн мэдлэг, туршлагыг солилцох үүднээс Европын Байгаль Орчны Агентлагийн ажлын "Эрт сэрэмжлүүлгээс гарсан сүүлчийн сургамж" гэсэн хоёр тайланг (EEA 2001, 2013) уг сургалтанд ашигласан юм. Сургалтын агуулгыг багцалбал Тогтвортой хөгжилд шилжих нь, Түүх ба алсын хараа, Инноваци, эрсдэл, боломж ба бизнес, Шинжлэх ухаан ба урьдчилан сэргийлэх зарчим, Удирдлага дахь урьдчилан сэргийлэх зарчим ба инноваци гэсэн сэдвүүдэд хуваагдаж байсан. Монгол, Орос, Пакистан, Энэтхэг, Вьетнам, Египет, Мексик, Унгар, Австрали, Аргентин, Франц, Герман, Украин, Беларус, Латив, Мавритий зэрэг 16 улсын 36 багш судлаачид оролцсон. Будапештын Төв Европын их сургууль, Данийн Техникийн их сургууль зэрэг олон орны их сургуулиуд болон мэргэжлийн байгууллагуудаас сонгогдсон, урьдчилан сэргийлэх зарчим, байгаль орчны болон эрсдэлийн удирдлагаар мэргэшсэн 20 орчим эрдэмтэн, профессор, докторууд энэхүү сургалтыг удирдан явуулсан юм.

Төслийн гол зорилго нь олон улсын хамтарсан докторын сургалтын нэгдмэл хөтөлбөрийг шинээр боловс-

хотуудын засаглал, хот суурин, хот орчмын газрын чанарын асуудлууд, төслийн төлөвлөлт, шилжилтийн менежментийн арга зүй, ухаалаг хотуудыг хөгжүүлэх олон улсын шилдэг туршлагауд, ногоон коридор, ногоон дэд бүтцийн хөгжил, хотын дэд бүтцийн менежмент, ухаалаг хотыг хөгжүүлэхэд мэдээллийн технологийг хэрхэн ашиглах, судалгааны арга зүй зэрэг тал бүрийн тулгамдсан асуудлуудыг хөндөн ярилцсан байдаг. Гол зорилго нь байгаль орчны бодлого, менежмент, технологийн чиглэлийн ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг сайжруулах, судлаачдын судалгааны чадавхыг бэхжүүлэхэд мөн чиглэгдэж байсан юм.

Энэ сургалтанд Монгол, Чех, Америк, Энэтхэг, Герман, Украин, Молдав, Нидерланд, Вьетнам, Унгар, ОХУ, Пакистан зэрэг 12 орны ERASMUS+ INTENSE төсөлд оролцогч сургуулиуд болон бусад их сургуулийн 40 судлаач оролцсон бөгөөд Чех (Czech Agricultural University), Словак (Slovak Life Science University), Нидерланд (Erasmus University Rotterdam), Польш (Warsaw Life Science University, Opole University of Technology), Унгар (Central European University), Орос (Institute for Geography and Ecology, Siberian Federal University), Беларус (Belarusian-Russian University), Итали (University of Camerino and University of Catania), Естон (Estonian University of Life Sciences), Герман (Martin Luther University of Halle-Wittenberg) зэрэг улсын мэргэшсэн эрдэмтэн профессорууд, докторууд удирдан, зохион байгуулсан.

#### -Төслийн даалгаврын дагуу одоо ямар ажил хийгдэж байна?

- Докторант оюутнуудын судлах хичээлийн хөтөлбөрийг харилцан санал солилцож боловсруулж байна. Мөн оюутны ерөнхий чадвар болон судалгааны чадварыг ахиулах ямар хичээлүүд байж болохыг хамтрагч байгууллагууд хүлээсэн үүргийн дагуу орчуулан боловсруулах ажил хийгдэж байна. Үүнд: Ховд их сургууль судалгааны курс-6, ерөнхий чадварын

гийн нийцтэй байлгахад дараахь хэдэн зүйлд зайлшгүй анхаарах цаг болж байна.

Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд орчин тойрныхоо зам, талбайг байнга цэвэр байлгаж, ногоон байгууламжийг өргөтгөх, 7 хоногийн нэг өдөрт тодорхой цагт энэ ажлыг хамт олноороо хийж байхыг хэвшил болгох.

Архи, пиво, ундааны шилээ хагалж хог болгохгүй бүрэн бүтнээр нь байлгаж ойролцоо хогийн саванд хийж хэвших, пиво ундааны сав, илүүдэл цаасыг / гялгар уут болон тамхины иш / хогийн саванд хийдэг болгох нь соёлтой хүний эн тэргүүнд эрхэмлэх ажил байвал зохино.

Хятадын Хунань мужийн нутаг Жанжнажэ хотод очиж нүдээрээ үзээд ирсэн хүн тэнд хогийн саваа савандаж угааж байна, ганц ширхэг тамхины иш, гялгар уут алга байна гэснийг зориуд тэмдэглэе.

Хот тохижуулахын ажилтнууд чинь та бидний нэг хэсэг шүү дээ. Өнгөрөгч хавар, зун ногоон байгууламж бий болгох гэж хувин саваар усаа зөөж, хоёр нарны хооронд борви бохисхийлгүй ажиллацгаасныг хотын бүх иргэд та бид бүгд мэдэх билээ. Үр дүн ч нүдний өмнө ил байсан.

Тэд ер нь хотын доторхи хог новш бүхнийг цэвэрлэж зайлуулах төрөлх хотоо цэвэр цэмцгэр соёлтой байлгахын төлөө өөрөөс шалтгаалах бүхнийг хийж байна. Иймд хүүхэд багачуудаасаа эхлээд бүх иргэд тэдний хөдөлмөрийг үнэлэх хэрэгтэй байна.

Иймийн тулд дээр дурьдсан хэдэн санаанаас санаа авч ургуулан бодож хотоо баруун бүсийн үлгэр жишээ тохижилттой хот болгоход та бидний хүчин чармайлалт нэгэн үзүүрт чиглэгдэх аваас хот нь цэвэрхэн тохитой, соёлтой, хүмүүс нь бухимдалгүй тайван ажиллаж амьдарч сурах нөхцөл бүрдэх учиртайг нийт иргэд ухамсарлах хэрэгтэй байна.

Энэ дашрамд хотын доторхи золбин нохой малын асуудлыг яаралтай цэгцлэх хэрэгтэй. Эзэнгүй нохойг ном журмын нь дагуу алив нэг эрсдэл үүсгэхгүйгээр устгах, хот дотор бэлчээрлэх үхрийн эзэдтэй тодорхой хариуцлага тооцох, малаа байвал зохих байршилд нь байлгах, нохой бол хотыг бохирлож, үхэр ногоон байгууламжийг сүйтгэж байгаад иргэд бухимдалтай байгааг дурьдахад илүүдэхгүй болов уу.

Бүтээлч хөдөлмөрөөр ямар их бүтээн байгуулалтын ажил хийгдэж байсныг ахмад үеийнхэн сайн мэдэх билээ.

Иймд урин дулааны цаг эхлэхэд одооноос урьдчилан сайтар бэлтгэн төлөвлөж үнэхээр бүтээлч ажил хийцгээе.

АХМАД НАСТАН Ч.ДАМБАДАРЖАА

## Уриалга

Зэрэг сумын Ахмадын хороо хорт хавдрын 10 хувийг үүсгэж, ус бэлчээрийг бохирдуулагч гэр ахуйн хуванцар сав суулга, гялгар уутыг цэвэрлэх 30 хоногийн бүтээлч ажил зохион байгуулж, нийт 1356 ширхэг хуванцар эдлэл, 3284 ширхэг гялгар уутыг устгалаа.

Цаашид энэ төрлийн хэрэглээнээс татгалзах зорилгоор сумын нийт ард иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагуудад энэхүү уриалгыг гаргаж байна. Үүнд:

1. 2019 оны 01 сарын 01-нээс эхлэн бүх нийтээр хүнс хадгалах хуванцар сав суулга, гялгар уут, гэр ахуйн бусад бүх төрлийн сав, бүтээгдэхүүнээс татгалзаж, хэрэглээнээс хасах.
2. Одоо өөрийн амьдарч байгаа хашаа хороо, түүний эргэн тойронд байгаа болон бэлчээрт байгаа хог хаягдлыг шатахыг нь шатааж устгах.
3. Машин, гар утас, гар чийдэн, радио гэх мэт бүх төрлийн цахилгаан хэрэгслийн хугацаа дууссан батерейг нэгдсэн цэгт төвлөрүүлэх зэргээр хүн бүр өөрийн болон гэр бүл, үр хүүхдийнхээ эрүүл мэндэд анхаарч өвчилсний дараа бус урьдчилан сэргийлж ажиллахыг та бүхэнд уриалж байна.

ЗЭРЭГ СУМЫН АХМАДЫН ХОРОО